

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведческих исследований

Том XXV • 2022 • № 4

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Посвящается 150-летию со дня рождения
российско-польского монголоведа
Владислава Людвиговича Котвича (1872–1944)

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук*
(Россия)
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор*
РАН (Россия)
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, про-*
фессор (Россия)
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 12.12.2022

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvove.ru

ISSN 2311-5939

DOI 10.25882/jrj4-8w22

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2022

© Коллектив авторов, 2022

В НОМЕРЕ:

Вл. Л. Котвич (1872–1944) — российский Ученый и Учитель (И. В. Кульганек)	5
ЛИНГВИСТИКА	11
Мөнхбатын ОЧИРЦЭНД. Дархад аман аялгууны эгшиг авиалбарын тогтолцоо (Система гласных фонем дархатского диалекта)	11
ЛИТЕРАТУРОВЕДЕНИЕ И ТЕКСТОЛОГИЯ	21
Чулууны ЗАЯАСҮРЭН. Гэрийн ерөөлийн бичмэл судруудын уран сайхны онцлог (Художественные особенности сутры благопожеланий дому)	21
Дашнямын МӨНХ-ОТГОН. Исследование версии на тибетском языке дидактических стихов Равджи «Бумажная птица»	28
ФОЛЬКЛОР И ЭТНОГРАФИЯ	37
Г. А. Дорджиева, С. В. Подрезова. Ранние записи калмыцкой музыки в Фонограммархиве Пушкинского Дома: экспедиция А.В. Бурдукова и Ф.Н. Гоухберг 1939 года	37
НАУЧНАЯ ЖИЗНЬ	50
М. В. Федорова. Выставка «Народы Великой степи: буряты, калмыки» в Российском этнографическом музее	50
О. В. Жербанова. «Времен связующая нить»: выставки живописи, графики и каллиграфии. Санкт-Петербург. 12–30 июня 2022 г.	57
Н. В. Ямпольская. Рец. на: Инеднты калмыцкого фольклора из архива И. И. Попова: несказочная проза и малые жанры / сост., перевод Б. Б. Горяева, С. В. Мирзаева, Д. В. Убушиева. — Элиста: КалмНЦ РАН, 2021	63
И. В. Кульганек. Новые книги по монголоведению	68

Чулууны ЗАЯАСҮРЭН

ГЭРИЙН ЕРӨӨЛИЙН БИЧМЭЛ СУДРУУДЫН УРАН САЙХНЫ ОНЦЛОГ

Монгол аман зохиолын нэгэн хэсэг ерөөлийн дотор хамгийн сонирхолтой, олон хувилбартай нь гэрийн ерөөл юм. Энэ нь бичгээр болон аман гэсэн хоёр хэлбэрээр бидний үед уламжлагдан ирсэн байдаг. Жишээлбэл, «Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai», «Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba», «Ger-ün irügel kemegdekü orusibai», «Sin-e ordu örgege -ü irügel» зэрэг судрыг нэрлэж болно. Эдгээр бичгээр уламжлагдан гэрийн ерөөлийн судруудын агуулга тус бүрийн онцлогийг тодруулж, хооронд нь харьцуулж, өөрийн санал дүгнэлтээ дэвшүүлсэн болно. Судруудын агуулга нь монголчуудын аж амьдрал, үйл хэрэг саадгүй бүтэхийн зөн бэлгэдэлт цогцолбор шинжтэй байгааг тодруулав.

Мөн судруудын агуулгын дүрслэлд элбэг хангалуун байхыг хүсэж мөрөөдсөн, ирээдүйд сайн сайхан, эд хөрөнгө тогтохыг аргадаж гуйсан дүрслэл голлож байна. Энэ нь монголчуудын өдөр тутмын амьдралын хэв маягт давамгайл оршдог дотоод сэтгэлийн хүчинд итгэж, найдах далд сэтгэлгээ тусгалаа олсныг жишээ баримтаар харуулсан болно.

Түлхүүр үг: гэрийн ерөөл, бэлгэдэл, уламжлал, дөрвөн судар, харцуулсан нь, дүрслэл, тайлбар

Зохиогчийн тухай: Чулууны ЗАЯАСҮРЭН, Ph.D, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Аман зохиол судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан (Улаанбаатар, Монгол Улс) (czayasuren@gmail.com).

© ИВР РАН, 2022

© Заяасүрэн Ч., 2022

Монгол аман зохиолын аман яруу найргийн нэгэн хэсэг бол ерөөл бөгөөд ахуй амьдрал, ажил хөдөлмөр зэрэг олон хүндэтгэлийн ёслолд ерөөлийг өргөн дэлгэр хэрэглэсээр иржээ. Ерөөлийн дотор хамгийн олон хувилбартай, сонирхолтой төрөл нь гэрийн ерөөл юм. Монголчууд шинэ гэр, байшингаа бариад хамгийн анхлан гэрийн буян хишгийг нь магтан дуудахдаа итгэл бишрэлийн үүднээс үгийн урлагтай хослуулан ерөөл хэлдэг уламжлалтай. Тэрхүү үгийн урлагийн зохиогчид нь ард түмэн өөрсдөө бөгөөд үе үеийн ардын цэцэн билигтний авьяас билгээр дүр дүрслэл нь баяжин, шигшигдэж ирсэн юм.

Гэрийн ерөөл нь аман болон бичгийн гэсэн хоёр хэлбэрээр уламжлагдан иржээ. Бидний үед бичгийн дурсгалаар уламжлагдсан “Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”, “Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba”, “Ger-ün irügel kemegdekü orusibai”, “Sin-e ordu örgege-ü irügel” зэрэг цөөнгүй судар байна. Энэхүү өгүүлэлд эдгээр судрын агуулга тус бүрийн онцлогийг тодруулж,

хооронд нь харьцуулах оролдлого хийсэн болно [Билгүүдэй, Отгонбаатар, Цендина 2018].

А). Судруудын агуулга:

1. “Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai” хэмээх гэрийн ерөөл нь 17.7 × 8.5 см хэмжээтэй орос цаасан дээр хар бэхээр монгол бичгээр бичжээ. Ерөөлийн бичвэр нийтдээ 19 мөр шүлгээс бүрдэл болжээ.

Эхлэл хэсэгт, Ум сайн амгалан болтугай гэсэн бурхан шашны бэлгэт үгээр эхэлж, өлзий дэмбэрэл бүрдсэн гэрийн эзэнд ээлтэй сайн өдөр гэрээ барьж, арван зүгийн гурван цагийн (өнгөрсөн, одоо, ирээдүй) бурхдад сүслэн залбирч, үгийн сайхнаар ерөөж, идээний дээжээр мялааж байна. Сударт гэрийг бүрэлдүүлж байгаа эдлэл хэрэгслийг шүлэглэхдээ тэдгээрийн бүтсэн эдийг “бургас”, “нарс”, “хус” гэж нэрлэн заажээ.

“...Бургасаар хийсэн хана...”

Нарсаар хийсэн унь...

Хусаар хийсэн тооно нь ану

Бөх бат болтугай...”

Эдгээр модыг монголчууд урт удаан хугацааны турш эдэлж, хэрэглэхэд хамгийн бат бөх,

хөнгөн авсаархан байдгийг ахуй амьдралын туршлагаар ажиглан, танин мэдэж, ухаарснаа гэрийн ерөөлийн сударт тусгажээ. Мөн муу муухай бүхнийг устаж үгүй болохыг хүсэмжлэн гуйгаад хотол бүгдээрээ энх амраар жаргахыг бэлгэдсэн үг хэлж “шагайт чөмөг, уураг сүүлээр мялаанам” гэж байгаа нь элбэг дэлбэг, өөг цатгалан байхын бэлгэдэлт утгыг илэрхийлж байна.

“Гэр мялаахад хонины годон сүүл, шаант чөмгийн хамт хадагт ороон ерөөлч түүнийг барьж мялаалгын ерөөл хэлдэг заншил байсан” [Хорлоо, 1969. Х. 27] бөгөөд энэ бүхэн нь дээрх ёс заншлыг эртнээс шинэ гэрийн ёслол буюу хуримын ёсонд ч бэлгэшээн хэрэглэж байсныг нотлон харуулах нэг баримт болдог юм.

Сударт гэрийн оосор бүслүүрийг ямар малын хялгас ноосоор хийсэн тухай дүрслэхдээ,

“...Хонь ямааны ноосоноор томсон оосор ану

Хотлон навч цэцэг мэт найгалзан байтугай...” гэсэнд хонь, ямааны ноосоор томж хийсэн бүслүүр нь бусад малынхаас чанартай, өнгөрсөн одоо ирээдүй гурван цаг, гурван үеэрээ бат бэх байхын бэлгэдэлт утгыг илэрхийлнэ. Мөн өргөө гэр нь байгалийн ямар нэгэн үзэгдэлд тогтвортой, хөдөлгөөнгүй байхыг хүссэн санаагаа илэрхийлэхдээ,

“...Хуй салхинд үл хөдлөн

Хот байшин мэт бөх тогтугай...

“...Энэ өргөө ану

Хаш хад мэт бөх бат болтугай...” гэж хүмүүсийн амьдран суудаг гэр нь хот байшин, хаш

хад шиг бат бөх байхыг адилтган бэлгэджээ.

Судрыг,

“...Буян хишиг хамаг хүсэл ану

Номын ёсоор бүтэх болтугай

Лам гурван эрдэнийн зарлигийн өчил

Бурхан бодисад нарын адистидын хүчин

Манай буян хишиг үлэмж гэрлийн хүчнээр...” хэмээн бэлгэдсэн үгээр төгсгөжээ. Мөн уг сударт, “Болтугай” гэх үгийг 18 удаа давтсан бол, хамаг улс, хан харцас, хэн бүхэн урт насалж, гэрийн эзэн насан эцэс хүртлээ амар тайван байхыг хүссэн санаагаа “жаргатугай” гэх үгээр 7 удаа давтан илэрхийлжээ.

2. “Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba” хэмээх гэрийн ерөөлийн судар нь 35.1 × 11.1 см хэмжээтэй орос цаасан дээр ягаан бэхтэй үзгээр монгол бичгээр бичжээ. Ерөөлийн бичвэр 19-20 мөр шүлгээс бүрдэл болжээ.

Ум сайн амгалан болтугай гэсэн бурхан шашны бэлгэт үгээр эхэлж, эртнээс нааш гэрийг бүтээснээс хойш эрхэмлэн хүндэтгэж, бишрэн шүтэж ирсэн уламжлалт ойлголтынхоо хүрээнд гэрийн тэнгэрт мөргөхийг зөвлөсөн байна.

Мөн судар,


“...Хөвчин дөрвөн харийн дотор

Хөх монгол [мидун=модун] махбод

Хүрдэн хэвтэй гэрийг үүдэж

Хүйт толог хянган хууль буй

Шинэ гэрийг сайтар баривуй...” гэж хүрдэн хэвтэй гэр хэмээсэн уран дүрслэлээр үргэлжилж байна.



Зураг 1. “Гэрийн ерөөл хэмээгдэх оршвой” (Ger-ün irügel kemegdekü orosibai) судрын эхний нүүр

Судрын дунд хэсэгт, гэрт гурван төрлийн зүйлээр өргөл өргөн, сацаж, мялаан баясгахыг зааварласан байдаг. Үүнд,

“...Сиддам арцыг сацмой

Шар тосоноор сүрчмой

Шидийн идээгээр бялмой...” хэмээн цэвэр ариуныг бэлгэдэж,

үнэртний дээд арцыг сацаж, шингэн шар то-соор цацах, идээний дээжээр мялаахыг тус бүр нарийн зааж өгчээ. Мөн, Бурхны шашны нөлөө сударт нэлээд шингэсэн байна. Тухайлбал, тооныг нэгэн зүйлийн хүрд, унь нь дэлгэсэн шүхэр мэт, хана цогийн зураг сүлжмэл, туурга тугийн далбаатай адил, дээвэр нь муруй загастай, хөлтрөг нь бадмын талтай адилхан хэмээн бүтэц хэсгээр нь зүйрлэн дүрсэлж, гэрийг дотор талаас нь харвал хүмх мэт цүлхгэр, гаднаас нь харвал лавай мэт цагаан гэж өлзийт найман тахилтай тус тус адилтгасан байдаг. Бас “...өршөөл мэт хаалга...” гэсэн нь монгол хүн хаалга үүдээр байнга буян орж ирдэг хэмээн ихэд бэлгэддэг үзэл ойлголттой холбогдоно.

Судрын төгсгөл хэсэгт, тухайн айл гэрт буян хишгийг хурайлан дуудаж ирүүлэх, тэрхүү урин залж ирүүлсэн буян хишгээ тогтоохыг зааварласан үгээр төгсгөжээ. Мөн, “болтугай”, “атугай” гэх үгийг 5 удаа, “жаргагтун” гэх үгийг 4 удаа давтаж, хүсэл гуйлтаа илэрхийлсэн байна.

3. “Ger-ün irügel kemegdekü orosibai” хэмээх гэрийн ерөөлийн судар нь 20.5 × 7.2 см хэмжээтэй орос цаасан дээр хулсан үзгээр хар бэхээр

монгол бичгээр бичжээ. Ерөөлийн бичвэр 21 мөр шүлгээс бүрдэл болжээ. Уг ерөөлийн өмнө оршил үг хэлснээрээ бусад судраас өвөрмөц онцлогтой юм.

Судрын оршил хэсэгт төвөдөөр аливаа өвчин зовлонгоос ангид байж, буян хишиг тогтохыг уриалсан агуулга бүхий 8 мөр шүлэглээд, ум сайн амгалан болтугай гэсэн бурхан шашны бэлгэт үгээр ерөөлийг эхлүүлжээ. Энэ нь бусад гэрийн ерөөлийн судруудтай ижилхэн. Түүнчлэн гэрийн модыг бэлтгэхдээ 2 янзын багажаар авсан тухай дүрслэн магтахдаа,

“...Сүхээр цавчсан мод чинь

Сүү цагаан гэр болтугай

Сүүн цагаан гэрт суусан эзэн чинь

Сүсэг сэтгэлээр жаргатугай...” хэмээн сүүшиг цагаан өнгөтэй болохыг бэлгэджээ. Улмаар тухайн гэрт суусан эзэн нь аливаад сүсэглэж, итгэснээр бүхий л зүйл бүтэж, сэтгэл хангалуун байх тухай санааг илэрхийлсэн бол дараагийн бадагт,

“...Оолиор огтолсон мод чинь

Өлзийт цагаан гэр болтугай

Өлзийт цагаан гэрт суусан эзэн чинь

Өдөр бүр өлзий хутгийн дунд явтугай...” гэх зэргээр ерөөжээ.

Ер нь монголчууд өргөө гэрээ ариун нандин, өлзий учралын бэлгэдэл болгож ирсэн уламжлалт сэтгэлгээтэй. Тиймээс “Монгол хүн гэрээ орчлон ертөнцийн загвар болгон дүрсэлдэг” [Дулам, 2018. Х. 146] байна.



Зураг 2. “Шинэ орд өргөөний ерөөл” (Sin-e ordu örgege-ü irügel) судрын эхний нүүр

Ерөөлийн дараагийн хэсэгт, гэрийнхээ модыг босгочоод эсгийгээр бүрдэг дарааллыг дүрслэхдээ,

“...Эсгийгээр бүрсэн гэр чинь
Бат цагаан гэр болтугай
Бат цагаан гэрт суусан эзэн чинь


Энх эсэн атугай...” гэжээ. Монгол гэрийн бүрээсийг хонины ноосоор хийдэг. Учир нь хонины ноосон эсгийд тослог их агуулагддаг бөгөөд гаднаас бороо шороо, хүйтэн салхи, нар нэвтрүүлдэггүй бат бөх байдаг. Ийм гэрт суусан эзэн нь эрүүл энх амьдарч, түүний ажил үйлс нь өдөр бүр бүтэж, сайн сайхан байхыг бэлгэдэх нь зүй ёсны хэрэг юм.

Судрын төгсгөлд,
“...Боржигон хаад энд өтөлж
Буян хишиг энд тогттугай...
Илгэгү энд донгодтугай
Аливаа сайн өвс энд ургатугай...”

гэснээс харвал уг судар зохиогдсон нутаг оронд үзэсгэлэнт шувуу донгодож, ургамлын сайхан ургахыг хүссэн санаагаа илэрхийлжээ. Бас нэг сонирхолтой дүрслэл байгаа нь “...нагац эх чинь энд ундалж...” гэсэн нь эхийн эрхт ёсны үед хамгийн хүндтэй хүн нагац эх байсан байх магадлал байна. Мөн тухайн гэрийн эзэн нас бүрдээ ажил үйлс нь бүтэхийг зөгнөн бэлгэдсэн бэлгэдэлт үгээр төгсжээ.

4. “Sin-e ordu örgege-ü irügel” хэмээх гэрийн ерөөлийн судар нь 30.4 × 8.2 см хэмжээтэй хятад цаасан дээр хулсан үзгээр хар бэхээр монгол бичгээр бичжээ. Ерөөлийн бичвэр 22 мөр шүлгээс бүрдэл болжээ.

Эхлэл хэсэгт, Есүхэй баатраас эхлэн дараагийн хаад хэний хэнтэй сууж, их орд өргөөгөө босгож, ерөөл айлтгуулсан тухай өгүүлдэг. Тухайлбал, Есүхэй баатар Хонгирад аймгийн салбар болох Олхонууд овгийн Өүлүн үжинг гэргийгээ болгож аваад орд өргөөгөө барьж, өөрийн сайдаараа ерөөлгөжээ. Эрт үед монголчууд гэргийгээ булааж авдаг ёс байсан нь тийм ч бүдүүлэг явдал биш юм. Харин ч хамгийн үзэсгэлэнтэй охидыг гэргийгээ болгохоор эрчүүд хоорондоо оюун ухаан, хүч чадлаараа тулалдаж ялалт байгуулсан нь авдаг ёс баатарлаг туульд ч дүрслэгдсэн байдаг. Энэхүү уламжлалын дагуу Есүхэй баатар Өүлүн үжинг авсан тухай ном зохиолд өгүүлсэн нь бий. Уг сударт мөн Их Монгол Улсыг үүсгэн байгуулагч Чингис хаан Хонгирад аймгийн Дай Сэцэний охин Бөртэ хатантай сууж, эрдэнэ мэт орд өргөөгөө босгож, өөрийн сайдуудаараа ерөөл хэлүүлсэн бол Хубилай сэцэн хааны 2 дахь хатан болох Хонгирад аймгийн Чабитай гэрлэж, Дайду их орд харшаа босгож, их зуу эрдэмтэн сайдаараа ерөөл айлтгуулсан тухай өгүүлжээ. Энд гарч байгаа Чаби хатан бол Хубилай хааны хамгийн хайртай эхнэр байсан бөгөөд төрийн үйл хэрэгт оролцохын зэрэгцээ хятадын торгоны урлалыг шинэ түвшинд хүргэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн гэдэг. Түүнчлэн, тайж ноёд өлзийт цагаан өргөөгөө босгож, өрлөгүүд сайдаараа ерөөл айлтгуулан суунам гэх зэргээр бидний өвөг дээдсийг дурдан танилцуулж байгаа маягаар сударт тусгагджээ.



Зураг 3. “Гэрийн ерөөлийн судар хэмээгдэх оршвой” (Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba) судрын эхний нүүр

Судрын үндсэн хэсэгт, гэрийг бүрэлдүүлэхдээ төрөл бүрийн модыг залж матаж сүхээр цавчиж бэлтгэсэн тухай, түүнчлэн, босгосон гэрийн модоо цагаан эсгийгээр бүрдэг дараалсан үйл явцыг дурджээ. Тухайн гэрт суусан эзэн нь тухайн улсынхаа эзэн нь болж, үргэлжид нар мэт ургаж, навч цэцэг шиг дэлгэрч явахыг хүссэн санаагаа харуулжээ.

Судрын төгсгөл хэсэгт, тухайн айл гэрийн эзний хүссэн санааг илэрхийлэхдээ,

“...Олон монголын төр шажин энд тогттугай

Бурхан мэт хөвгүүнтэй болтугай

Будаан тариан мэт олон малтай болтугай

Малтай бурсан хуврагуудыг тахиx буянтай болтугай

Ном мэт ихэд дэлгэртүгэй

Ноёд сайдын зэрэгт орох хөвгүүнтэй болтугай

Нуур далай мэт эд идээтэй болтугай...”

“...Энэ өлзийт өдрөөс хойш

Одноос олон цагаан малтай

Уулнаас их цагаан гэртэй болтугай...” гэсэн төгсгөл хэсэгт “тогттугай”, “болтугай” гэх мэт ерөөн бэлгэдсэн үгээр төгсгөжээ. Энэ нь монголчууд байгаль дэлхийгээс өөрийн хүссэн зүйлээ гуйхдаа тухайн санаагаа тодотгосон үгсийг давтаж, ахин дахин хэлж, уг санаагаа хүчжүүлж, эрчимжүүлдэг тэдний өвөрмөц сэтгэлгээний онцлогийг илтгэн харуулж байна. Мөн болтугай гэх үгийг 13 удаа давтсан бол дэлгэртүгэй-4, урстугай-3, ургатугай-3 тус бүр давтжээ.

Б). Судруудын дүр дүрслэлийг харьцуулсан нь:

Судрын нэр	“Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”	“Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba”	“Ger-ün irügel kemegdekü orosibai”	“Sin-e ordu örgege-ü irügel”
Гэрийн эдлэл хэрэгсэл дүрслэгдсэн нь,	Бургасан хана, нарсан унь, хусан тооно, эсгий, босго, хацавч, хөшиг,	Тооно, унь, хана, туурга, дээвэр, хөлтрөг, хаалга, хатавч, босго	Мод, эсгий, хацавч, босго,	Хана, тооно, эсгий, оосор, босго хацавч
Өргөл өргөж, мялааж буй зүйл,	Шагайт чөмөг, уураг сүүл	Сиддам арц, Шар тос, шидийн идээ	=	=
Гэрийн эдлэл хэрэгслийг бусад зүйлтэй адилтган бэлгэдсэн нь,	Сүүн цагаан өргөө, орд цагаан гэр, эрдэнэ цагаан өргөө, Хана, унь, хөшиг-бат бэх, гэр-эрдэнэ цагаан лавай мэт, оосор нь-хотлон навч цэцэг мэт, хоймор татсан хөшиг-сүм балгад мэт, өргөө нь-хад мэт бат бөх,	Сүүн цагаан гэр, өлзийт цагаан гэр, бат цагаан гэр, Тооно-хүрд, унь-шүхэр, хана-цог залийн сүлжмэл, гэрийн дотор тал-хумх мэт цүлхгэр, туурга-тугийн далбаа, дээвэр-муруй загасан, хөлтрөг нь-бумбын талтай, гадар тал нь -лавай адил, өр-шөөл мэт- хаалга, журам мэт-2 хатавч, ёс юүгээн мэт-босго	Сүүн цагаан гэр, өлзийт цагаан гэр, бат цагаан гэр,	Гэр нь-эрдэнэ цагаан лавай мэт, хоймор татсан хөшиг-сүм балгад мэт, өргөө нь-хад мэт бат бөх, баруун талаар татсан хөшиг-бат бөх, урдуур татсан хөшиг-түвшин бат,

Судрын нэр	“Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”	“Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba”	“Ger-ün irügel kemegdekü orosibai”	“Sin-e ordu örgege-ü irügel”
Лам, бурхад, түүхэн хүмүүсийн нэр,	Бурхан бодисад, лам гурван эрдэнэ	Богд лам	Боржигон хаад, эрдэнэ сайд	Бурхан бодисад, Есүхэй баатар, Өүлүн хатан, Чингис хаан, Бөртэ хатан, Самантабадра, Тулуй, Хубилай сэцэн, Чаби хатан,

Дээрх харьцууллаас харахад, нэгдүгээрт, “Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”, “Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba” гэх сударт гэрийг бүрэлдүүлдэг эд зүйлийг дэс дараалан тоочихдоо хэрхэн ямар модоор хийсэн, эдлэл хэрэгсэл бүр ямар эд зүйлтэй адил төстэй байгаа онцлог шинжийг нь адилтгаж дүрсэлсэн бол, “Ger-ün irügel kemegdekü orosibai”-д: гэрийн модыг ямар багажаар авсан, тухайн гэрээ эсгийгээр бүрсэн тухай дүрсэлжээ. Бусад эд хэрэглэлийг тоочин дүрсэлсэнгүй. Мөн, “Sin-e ordu örgege-ü irügel”-д: гэрийн эдлэл хэрэгслээс хана, тооно, эсгий, оосор гэсэн гэрийн голлох эдлэл хэрэгслэлийг л тоочин хэлжээ.

Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”, “Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba” зэрэг нь илүү тайлга тахилгын шинжтэй байна. Мөн эдгээр судраас “Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba” судрын дүрслэлд бурхан шашны нөлөө их шингэсэн болох нь тов тодорхой харагдаж байна.

“Sin-e ordu örgege-ü irügel” судрын дүрслэлээс харахад XIII зууны түүхэн хүмүүсийн угсаа гарвацийг танилцуулсан нь танин мэдэхүйн шинжтэй болсноороо бусад судрын дүрслэлээс онцлогтой.

Судруудын агуулгад сүүн цагаан гэр, орд цагаан гэр, эрдэнэ цагаан өргөө, өлзийт цагаан гэр, бат цагаан гэр гэхчлэнгээр хүндэтгэн нэрлэжээ. Энэ нь нүүдэлчид гэрээ бүхнээс ариун нандин байлгахыг хүссэн, түүнд суусан эзэн нь үргэлжийн мөнхөд жаргалтай байх санаагаа

илэрхийлсэн тэдний сэтгэлгээний онцлог юм. Цагаан гэр гэдэг ойлголтыг танихуйн үүднээс нь авч үзвэл эрт үеэс холоос бараатай харагдах байдлыг чухалчлан бүтээсэн, бүхий л өнгийн эх өнгө гэдэг агуулга бас гарч байна.

Судруудад дүрслэлийн ялгаа байгаа нь тухайн судрын зохиогчийн уран чадвар, сэтгэлгээтэй холбоотой юм.

Дээрх судруудын дүрслэлийн бүтцэд “бол-тугай, дэлгэртүгэй, орштугай...” гэх мэт үгсээр тухайн хүссэн санаагаа гүйцэлдүүлэхийг өгүүлэгчийн бэлгэдэн хүсэх утга илэрч байна.

“Erten-ü boyda narača ündüsülegsen ger-ün irügel-ün sudur orusibai”, “Ger-ün irügel kemegdekü orosibai”, “Sin-e ordu örgege-ü irügel” гэсэн сударт ижилхэн дүрслэл байгаа нь сонирхол татах ба зохиогдсон цаг хугацаа, газар нутгийн байршил, зохиогчдын хоорондын хамаарал үүнд нөлөөтэй гэж үзэж болох юм. Тухайлбал,

“...Босгоноос тань бор булаг дэлгэртүгэй

“...Хацавчнаас тань хар булаг дэлгэртүгэй...”

гэсэн дүрслэл 3 сударт байгаа юм. Босгыг тухайн айлд буян хишиг ордог үүд хэмээн үздэг. Мөн монголчууд ямар нэгэн тохиолдлоор босгоны доорх газраас гэнэт ус дэлбэрэн гарах юм бол элбэг хангалуун байх нь гэж ихэд бэлгэшээдэг уламжлалт үзэл ойлголтыг эдгээр сударт шингээжээ.

Судруудын агуулга нь монголчуудын аж амьдрал, үйл хэрэг саадгүй бүтэхийн зөн бэлгэдэлт цогцолбор шинжтэй байна.

Судруудын агуулгын дүрслэлд элбэг хангалуун байхыг хүсэж мөрөөдсөн, ирээдүйд сайн

сайхан, эд хөрөнгө тогтохыг аргадаж гуйсан дүрслэл голлож байна. Энэ нь монголчуудын өдөр тутмын амьдралын хэв маягт давамгайл

оршдог дотоод сэтгэлийн хүчинд итгэж, найдах далд сэтгэлгээний онцлогийн тусгал юм.

НОМ ЗҮЙ

1. Билгүүдэй, Отгонбаатар, Цендина 2018: Билгүүдэй, Г., Отгонбаатар, Р., Цендина А. Ц. Дамдинсүрэнгийн гэр музейн монгол ном судрын бүртгэл. Нэмэлт галиг болон ном, зохиогчийн нэрсийн хэлхээг хийж, ариутган шүүсэн А. Туранская, Н. Ямпольская, редактор С. Байгалсайхан, Улаанбаатар, 2018.

Bilguudei G., Otgonbaatar R., Tsendina A.Rs. Damdinsurengiin ger muzein mongol nom sudryn burtgel [Registration of Mongolian books in Ts. Damdinsuren's home museum]. Ulaanbaatar. 2018.

2. Дулам, 2018: Дулам, С. Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа / Эрдэм шинжилгээний өгүүлэл-II боть эрхлэн хэвлүүлсэн Д. Заяабаатар, эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн Г. Нандинбилиг, А. Цэнд-Аюуш, Улаанбаатар, 2018.

Dulam S. Mongol aman zokiol, khar'tsuulsan aman zokiodyn sudalgaa [Study of Mongolian oral literature and comparative oral literature]. Ulaanbaatar, 2018.

3. Хорлоо, 1969: 27: Хорлоо П. Монгол ардын ерөөл / Редактор Б.Содном, Улаанбаатар, 1969.

Khorloo P. Mongol ardyn erool [Mongolian folk well-wishes]. Ulaanbaatar. 1969.

THE ARTESTIC FEATURE OF MANUSCRIPT'S ON HOME FELICITATION, BLESSING

Chuluun DSAYASUREN

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

The home blessing is the most interesting part of the Mongolian oral art and includes many types. It has been handed down to our time in two forms: written and oral. "Erten-ü boyda narača ündüsülegsен ger-ün irügel-ün sudur orusibai", "Ger-ün irügel-ün sudur kemegdekü orusiba", "Ger-ün irügel kemegdekü orosibai", "Sin-e ordu örgege -ü irügel" manuscripts have been inherited to our time.

By clarifying the specifics of each of these manuscripts and trying to compare them, it will help both theoretically and practically in the research of this subject. The author clarified that the content of the manuscripts symbolize the successful functioning of Mongolian people's lives and affairs. Moreover, the paper reveals that the content of the manuscripts mostly focuses on the description of dreams of abundance and asking for prosperity and wealth in the future. It is an example of the hidden mentality of trusting and relying on the power of the inner soul, which prevails in the daily lifestyle of Mongolians.

Key words: home blessing, Mongolian, four manuscript, symbolic, feature, traditional, description

About the Author: **DSAYASUREN Chuluun**, Ph.D, Associate Researcher, Institute of Language and Literature Folklore of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (czayasuren@gmail.com).